

## ТЭВЧЭЭРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ БА ОРЧИН ҮЕ

Г.Ичинноров - ХоИС. НХУС. Нийгмийн ухааны тэнхимийн багш, докторант

**Түлхүүр үг:** нигүүлсэхүй, хайр, зөвшилцөл, хилээцэт байдал, шударга ёс,

**Товч утга:** Энэхүү өгүүлэлдээ “тэвчээр” хэмээх философи-ёс зүйн ойлголтыг онцлон судалж түүний мөн чанар, үнэ цэнэ, философи дахь тэвчээрийн тухай асуудлыг хөндөж гаргасан юм. Тэвчээртэй байхын тулд аливаад хүлээцтэй хандаж, харилцаанд “алтан дүрэм”-ийг баримтлах нь чухал байдаг. Харилцан зөвшилцөж, бие биенээ сонсож, нэгэндээ хүндэтгэлтэй хандсанаар асуудлыг эерэгээр шийдэж чаддаг. Амьдралд олон янзын бэрхшээл тохиолддог. Хэн нэгэнд гомдох, уй гашуу тохиолдох, атаархаж хорсох гэх мэт олон зүйлийг тэвчээрийн хүчээр даван туулах боломжтой. Энэ бол тэвчээртэй байхын ач тус.

“Тэвчээртэй байх” нь орчин үеийн иргэний нийгмийн ялангуяа хувь хүний, улс үндэстний ёс суртахууны эрхэмлэл, гол зарчим нь болох учиртай. Өнөө үед бие биенээ үл хүндэтгэсэн, бие биендээ үл итгэсэн, өөрийн гэмийг нууж, бусдын гэмийг шүүн хэлэлцдэг зохистой бус явдлын үрээр нэг нэгнийгээ хохироох, гомдоох үзэгдэл газар авсаар байна. Дээрх ёс суртахууны гаж үзэгдлүүдийг засан залруулах хамгийн гол хүчин зүйлсийн нэг бол тэвчээр байх учиртай.

Юун түрүүнд уг ойлголтын гарал үүсэл, нэр томъёоны талаар дурьдах нь зүйтэй болов уу.

Оросын эрдэмтэн Даль “Орос хэлний язгуур” бүтээлдээ: толерантность (хүлээцтэй байдал), терпимость (тэвчээр) хэмээх энэ үгсийг адил утга зааж байдаг талаар дурьджээ<sup>111</sup>. Мөн Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” бүтээлдээ: тэвчээр хэмээх үгийг хүлцэл, тэсвэр гэсэн утга зааж байдаг талаар дурьджээ<sup>112</sup>.

Толерантность-тэвчээр, хүлээцтэй байдал адил утгатай.

Тэвчээр нь хүлээцтэй байх, хүлцэх зарчим, хүлцэнгүй байдал, биеэ барих чадвар, үл хүчирхийлэл, уучлал гэсэн олон утга санааг агуулж байдаг.

Тэвчээр бол өөр сэтгэлгээтэй хүмүүстэй эерэг харилцахад бэлэн байх, идэвхитэй байдал, өөрийгөө болон бусдыг ойлгох үйлдэл. Өөрөөр хэлбэл, аливаад хүлээцтэй хандаж, харилцаанд алтан дүрмийг баримтлах зарчим юм.

Эртнээс эдүгээ хүртэл үеийн философи, ёс зүйн ном зохиолуудад тэвчээрийн тухай сургаал тодорхой байр суурь эзэлсээр иржээ. Тухайлбал: Сократ, Платон, Аристотель, Будда, даосизм, Америкийн философич М.Уолцер, Францын философич

---

<sup>111</sup> См. Даль В.И. Толковый словарь живого русского языка / М.: Русский язык - Медиа. 2007.

<sup>112</sup> Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 65 дахь тал

Ф.М.Волтер, М.Фуко, Mendus нарын бүтээлийг дурьдаж болно. Ингээд тэвчээрийн тухай асуудлыг философичид хэрхэн тайлбарлаж ирсэнийг авч үзье.

Хятадын даосист философид “Өрөөлийг ялагч хүн их хүчтэй байж таарна. Өөрийгөө ялагч хүн тэвчээрт хүн байж таарна” гэж тэвчихүйн ач тусыг сургажээ.

Грекийн стоикууд сайн үйл, айдас, гашуудал, нүгэл, цэнгэл жаргалыг тэвчихийг аскетизм гэж нэрлэсэн байдаг.

Сократ тэвчээргүй, зүрх зориггүй явдлыг буруушааж, тэвчээр, биеэ барих чадварыг магтжээ. Түүний үзлээр “Юуг хүсэх нь зохистой, ашигтай вэ? гэдгийг мэдэх нь” тэвчээрийн үндэс аж.

Грекийн философич Платон “Тэвчээр гэдэг нь өөрийгөө эзэмдэх, өөрийнхөө зовлон жаргалд эзэн болох чадвар” юм гэжээ. Тэвчээр нь дундаж байх, хэр хэмжээ таарах гэсэн ойлголттой салшгүй холбоотой учраас харилцаанд алтан дүрмийн агуулгаар хэрэгждэг. Мөн тэвчээрийг харилцан зөвшилцлийн ёс зүй ч гэж нэрлэж болох юм.

Аристотель “Захируулах, захирах чадварын аль аль нь сайшаалыг хүлээх ёстой. Иймд иргэний сайн үйл өөрөө сайн захирч, сайн захирагдаж чаддаг байхад оршино. Тэгээд бид сайн зүтгэлтний сайн үйл нь захирах чадварт, харин иргэний сайн үйл захирагдах чадварт оршино.” хэмээсэн нь “харилцан ойлголцох шаардлагаар тэвчээр гаргасан байдлыг хэлсэн бөгөөд үүнийг тэвчээрийн тухай анхны тодорхойлолт” гэж Америкийн философич М.Уолцер дүгнэжээ.

Францын философич М.Фуко: “Аскетизм нь соёл хоорондын харилцааны үндэс. Тэвчээр нь өөрийгөө хянах, хязгаарлах тул зохистой харилцаа бий болгох хийгээд шүүмжлэгч талуудын харилцан ойлголцлын арга” хэмээсэн нь эцсийн дүндээ алтан дүрмийн шаардлагатай утга адил гэдэг санаагаар бичсэн нь тодорхой.

Ёс суртахууны үнэлэмжинд тэвчээрийн асуудал холбогдохдоо:

- тэвчээр нь янз бүрийн уламжлалт үнэлэмжийг хүндэтгэх арга
- ёс заншил, зан үйл, хууль цааза дагана гэдэг бол тэвчээртэй холбоотой
- янз бүрийн үндэстэн угсаатнууд энх тайвнаар зэрэгцэн орших нь тэвчээрийг шаарддаг.

Тэвчээр нь хүмүүс бие биенийхээ гадаад байдал, үг яриа, амьдралын хэвшил, итгэл үнэмшилд нь хүлээцтэй, тэвчээртэй хандах буюу тэднийг үл ойлголцохоос сэргийлнэ. Гэвч зарим үед бусдын буруугийн өмнө хүлцэнгүй байхыг шаарддагаараа тэгш бус харилцаа мэт санагдана. Өөрөөр хэлбэл зарим буруушаасан үйлдэлд ч зохицохыг шаардаад байдаг. Жишээ нь шударга бус явдлыг дуугүй тэвчвэл хүлээн зөвшөөрөөд байгаа юм биш. Магадгүй уг асуудлыг зөв шийдэх цаг хугацааны боломж олгодог.

Нөгөө талаар шударга бус үйлдэл даамжрах, нийгэмд учруулах хохирол, гэм хор нь улам нэмэгдэх нөхцөл бүрдэхийг үгүйсгэхгүй. Нэгэнт ёс суртахууны сайн чанарыг шингээсэн хүн бол шударга бусыг зөвшөөрч дуугүй байхгүй нь ойлгомжтой. Ийнхүү

тэвчээр нь үндэсний уламжлал, ёс суртахуун, шашны итгэл үнэмшил гээд нийгмийн бүхий л харилцаанд хэрэгжих зарчим юм. Өнөөдөр янз бүрийн итгэл үнэмшил, соёлын уламжлал, улс төрийн итгэлцэлд тэвчээр нь харилцааны хийгээд соёлын гол элемент болоод байна.

Сайн сайхан, аз жаргал, хайр, нигүүлсэхүй сэтгэлийг хүссэн хэн бүхэнд тэвчээр агаар, ус мэт хэрэгтэй. Гэвч энэ нь муйхарлал, зөрүүдлээс эрс өөр юм. Хүн амьдралаас хэдий ихийг хүснэ, төдий чинээ тэвчээрийг шаардаж байдаг.

Тэвчээрийг үүсгэдэг олон хүчин зүйл байдаг. Үүнд: бидэнд учрах саад бэрхшээл, өш хонзон, уур хилэн, шунал, атаархал г.м. Эдгээр нь та бидний нөхөр мэт дайсан, дайсан мэт нөхөр минь билээ<sup>113</sup>.

Буддагийн сургаалд “Салхи үлээхэд хад асга үл доргих лугаа адил, ухаант хүнийг яаж ч загнаж зандагчсан, яаж ч магтаж өргөмжилсөн сэтгэл нь үл донсолж, амгалан байдлаа үл алдана. Өөрийгөө ялах нь дайны талбарт тоо томшгүй олон цэргийг дарж ялалт байгуулсанаас илүү”<sup>114</sup> хэмээн өгүүлжээ. Эндээс үзэхэд өөрийгөө ялан дийлэгч, ухаалаг хүн тэвчээртэй хүн. Иймээс тэвчээртэй хүн амар амгалан сайхан амьдарна.

Буддизмд буй нирваан, гэгээрэл, бодь сэтгэл хэмээх ойлголтуудын агуулга, багтаамжийг тэвчээрээс ангид тодорхойлох боломжгүй. Маанийн зургаан үсгийг урин уншиж зургаан билиг барамидыг төгсгөсөн гэдэг. Түвэдийн номт хаан Соронзонгомбо бээр: “Ни”-гээр тэвчээрийн билиг барамидыг төгсгөх утгыг илэрхийлнэ. Өш хонзонг тэвчих тэргүүтнээр тэвчээрт суралцдаг. Тэвчээр нь гурван зүйл бөгөөд 1. Зовлон шуудаар авахын тэвчээр, 2. Номд магадтай онохын тэвчээр, 3. Хорлолд үл ажрахын тэвчээр гэж үзжээ.

Тэвчээрийг илрэх агуулгаар нь: - угсаатны, - улс төрийн, - шашны, - соёлын гэж ангилж болно. Мөн түүнийг илрэх хэлбэрээр нь:

- болгоолмжлол
- үл хүчирхийлэл
- зөвшилцөл
- нигүүлсэхүй /уучлал/
- биеэ барих чадвар
- хүндэтгэл гэх мэтээр ангилж болох юм.

Гуманистуудын үзлээр “тэвчээр нь хүний оршихуй, ёс суртахууны хэм хэмжээгээр хандсан харилцан зөвшилцөл хүндэтгэл юм” хэмээн үзжээ. Ертөнцийн оршихуйг хангахын тулд тэвчээртэй байх ёстой агаад хүн өөрийн өвөрмөц чанараа хадгалах эрхтэй тул бусдаар оршихуйгаа зөвшөөрүүлэх амар биш ч тэвчээрийн хүчээр зохистой нөхцөлийг бүрдүүлнэ.

<sup>113</sup> М.Золзаяа. Ёс зүй. УБ.,2005. 25 дахь тал

<sup>114</sup> XIV Далай лам. Шинэ мянганы хүмүүн төрөлхтөний ёс зүй. УБ.,2003 15 дахь тал

Нөгөө талаар тэвчээр нь бусдад тэгш эрхийн зарчмаар хүндэтгэлтэй хандах ёс болно. Тэвчээртэй байснаар энэ ертөнцөд эцэг эх, гэр бүл, найз нөхөд, хамтран ажилладаг хүмүүс, эх болсон зургаан зүйл хамаг амьтанд амар амгалан бүрдэх болно.

Тэвчээр алдрах, аль юм болгоныг тэвчих вэ? гэх зэрэг нь бидэнд зовлон үүсгэдэг төөрөгдлийн нэг. Нэг талаар тэвчээртэй байх нь ямар арга замаар хэдий хугацаанд үргэлжилж байгаагаас хамааралтай юм. Хамгийн гол нь харилцагч этгээдүүдийн нэг нь тэвчээр алдаж байхад, нөгөө нь тэвчиж буулт хийх, асуудлыг бие биенийхээ эрх ашигт тэнцвэртэйгээр, эв эеэр зохицуулахын төлөө байх нь зохистой.

Өнөөгийн нийгмийн ёс суртахууны доройтол нь тэвчээртэй байхыг улам бүр шаардаж байна. Тэвчээртэй байх нь хүмүүний бие, хэл, сэтгэлийн гэмээс ангижрах, түүнийг анагаах гайхамшигт эм төдийгүй цээрлэх ёсоо дагах нэг нөхцөл болно.

Энэ бүгдийг дүгнэн үзвээс, бидний амьдрал баялаг бөгөөд бидний зан чанар ч олон янз байдаг. Иймээс бидний харилцааг журамлан сайхан болгодог ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ нь тэвчээртэй байх, үнэнч шударга байх, хашир хянамгай байх, хичээнгүй нямбай байх, ичих мэдрэмжтэй байх зэрэг олон хэлбэртэй юм. Хүний амьдралд саад бэрхшээлгүй зүйл гэж үгүй. Тэр бүхэнд тэвчээр хэрэгтэй. Бэрхшээлийг давах болгонд шинэ эрч хүч хуримтлагдан шинэ мэдлэг чадвар нэмэгдэнэ. Аливаа хүнд тэвчээртэй байх зан чанар төлөвшөөгүйгээс болж ажлыг хагас дутуу, ор нэрийн төдий хийж, үр дүнгүй болгодог байдал бодит амьдрал дээр цөөнгүй тохиолддог. Иймээс хүн ажлаас үл бэрхшээх, бусдыг үл зовоох, хулгай худлыг тэвчих, айлгах атаархахыг цээрлэх, эв эеийг хичээх зэрэг тэвчээрт суралцах нь хамгаас чухал.

### НОМ ЗҮЙ

1. Аристотель. Евдемийн ёс зүй. УБ.,2008
2. Аристотель. Никомаховын ёс зүй. УБ.,2007
3. XIV Далай лам. Шинэ мянганы хүмүүн төрөлхтөний ёс зүй. УБ.,2003
4. Ц.Гомбосүрэн. Ёс зүй. УБ.,2008
5. МУИС-НШУС.Философи, шашин судлал. УБ.,2009 №9
6. Күнз. Шүүмжлэлт өгүүллэг. УБ.,
7. М.Золзаяа. Ёс зүй. УБ.,2005
8. Даль В.И. Толковый словарь живого русского языка. М., Русский язык - Медиа. 2007.
9. Wikipedia. Modern definition about Toleration concept
10. Түвдэн Зопа Ринбүүчий. Буян ба бодит байдал. УБ.,2002
11. Laursen, John Christian. "Spinoza on Toleration" in *Difference and Dissent: Theories of Toleration in Medieval and Early Modern Europe*, edited by Nederman and Laursen (Lanham, Maryland: Rowman and Littlefield, 1996).
12. Mendus, Susan. "Locke: Toleration, Morality, and Rationality" in John Horton and Susan Mendus, eds., *John Locke: A Letter Concerning Toleration in Focus* (London: Routledge, 1991).
13. Walzer, Michael. *On Toleration* (New Haven: Yale University Press, 1997).